

ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙГ НИЙГЭМШҮҮЛЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Г.БАТТУЛГА

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа



Г.БАТЖАРГАЛ

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн багш, ахмад

Хураангуй: Энэхүү илтгэлээр хорих ял эдлүүлэх ажиллагааны нэг бие даасан онцлог чиглэл болох хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг нийгмээс тусгаарлан, ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулж буй өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар судалгаанд суурилсан санал дэвшүүлэхийг зорих юм.

Abstract: This presentation aims to provide recommendations that are based on studies about the current situation and the future of the imprisonment of juveniles, particularly the separation from society, one of the unique features of the imprisonment system.

Түлхүүр үгс: Хорих ял, хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүн, нийгэмшүүлэх ажил, Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, нийгмийн ажлын үйлчилгээ

Keywords: imprisonment, juvenile delinquent, rehabilitation work, Special organization for training and character building, services of social work.

Үндсэн хэсэг

Монгол Улсын эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар тусгасан байдаг. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын үндэслэл, онцлогийг уг бүлэгт дараах байдлаар хуульчилжээ.

Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн 8.1.4 дэх хэсэгт “Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэнэ”¹ гэжээ.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулахаар заасан.

Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай 1989 оны НҮБ-ын конвенцод 1990 онд нэгдэн орж, түүнийг өөрийн оронд хэрэгжүүлэх зорилгоор дотоодын хууль тогтоомжийг түүнд нийцүүлэн боловсронгуй болгоход анхаарсаар ирсэн. Нөгөө талаасаа Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Монгол улсын нэгдэн орсон конвенци дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

Энэхүү конвенцийн 40 дүгээр зүйлд “Оролцогч улсууд эрүүгийн хууль зөрчсөн гэм буруутай нь тогтоогдсон хүүхдийн нэр төр, үнэ цэнэ, эрхийг хангаж, бусдын үндсэн эрх чөлөөг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэх, нийгмийн амьдралд буцаан оруулах, нийгэмшүүлэх ажлыг тэдний насны онцлогийг харгалзан явуулна” хэмээн заасан бөгөөд конвенцод нэгдэн орсон улсын хувьд түүнийг сахиж, биелүүлэх үүргийг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд Өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ гэж заасан байдаг.

Манай Улсын хувьд анх өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлдэг тусгай байгууллагыг 1948 онд тухайн үеийн Дотоод явдлын яамны сайдын тушаалаар байгуулжээ. Улсын хэмжээнд цорын ганц энэхүү байгууллага нь 1964-1993 он хүртэл алслагдсан хөдөө орон нутагт байршиж байв².

¹ Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн 8.1.4 дэх хэсэг, Эрүүгийн хуулийн шинэчлэсэн найруулга 2015 он.

² 1964-1978 онд МАХН-ын Төв Хороо, СнЗ-ийн 1964 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 228\387 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Цагаан толгойд, 1978-1993 онд СнЗ-ийн 1978 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор мөн аймгийн Дарьтад тус тус байршиж байв.

Харин өнөөдөр Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага Нийслэлийн 110 дугаар бүрэн дунд сургууль гэсэн нэршил, бүтэц, тогтолцоотойгоор үйл ажиллагаа явуулдаг. Тус байгууллагад өнөөдөр 27 хүүхэд хоригдож байна. Тэдгээр хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах, засрал хүмүүжил олгох, нийгэмшихэд нь туслалцаа, дэмжлэг үзүүлэн хяналт тавин зорилгоор нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сургуулийн багш, удирдлагууд хамтран ажилладаг.

Тус байгууллагад нийгмийн ажилтан 1, сэтгэл зүйч 1 тус тус ажиллаж байгаа бөгөөд тэд 110 дугаар сургуулийн багшлах (сургалтын менежер-1, үндсэн багш-3, цагийн багш-4, гэрээт 6 багш) бүрэлдэхүүнтэй хамтран сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 110-р дунд сургууль нь анх Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2000 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 258 дугаар тушаалаар Хөдөлмөрийн төрөлжсөн сургалттай суурь боловсрол олгох тусгай сургууль нэртэй байгуулагдаж улмаар Нийслэлийн засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/545 дугаар захирамж гарч тус сургуулийн ангиллыг өөрчилж бүрэн дунд сургууль болсон байна.

Нийслэлийн 110 дугаар бүрэн дунд сургууль нь “Байгалийн ухаан”, “Математик”, “Мэдээлэл зүй”, “Компьютер”, “Монгол хэл” зэрэг 5 танхимд цөм хөтөлбөрийн хүрээнд хичээл сургалтыг зохион байгуулж байна.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас хэрэгжүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээ

1. **Хорих ял шийтгүүлсэн** өсвөр насны хүнийг тус байгууллагад хүлээн авснаас хойш нийгэмд суллагдан гарах хүртэл буюу хоригдох хугацаанд нь тус байгууллагын зүгээс ерөнхий боловсролын төдийгүй, зан үйлд нөлөөлөх, амьдрах ухааны, хүмүүжлийн эерэг нөлөө үзүүлэх, мэргэжлийн баримжаа олгох сургалтуудад хамруулдаг.

2. Сургалт хүмүүжлийн байгууллагад шинээр ирсэн хүмүүжигч хүүхдүүдтэй ганцаарчилсан уулзалт хийж, байгууллагын дотоод журам, хүмүүжигчийн эрх үүргийг тайлбарлах, ар гэрт нь мэдэгдэх, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын онцлогийн талаар тайлбарлан ойлгуулах, тэдний сэтгэл санааны байдлыг тодорхойлж, сэтгэл зүйн болон бусад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн нийгмийн ажил, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг.

3. Мөн хүмүүжигч хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тэдний онцлогийг харгалзан сургалтад хамруулах, сэтгэл зүйн сорил авах, тэдэнд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Кейс 1. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгааа “А” 17 настай: “Тус байгууллагад ирээд 1 сар гарантай болж байна. Ирсэнээсээ хойш “Хөгжмийн сургалт”, “Зургийн дугуйлан” бусад амьдрах ухааны сургалтуудад хамрагдсан. Өмнө нь Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид байхад айдас түгшүүр ихтэй, ходоод их өвддөг байсан. Гэвч энд ирсэнээс хойш ямар нэг зүйлд санаа зовох, айх зүйлгүй, сэтгэл санаа тогтуун болсон. Тус байгууллагын алба хаагчид бидэнтэй их ойр дотно харилцдаг. Заримдаа “Миний хүү ингээрэй тэгээрэй, ийм учиртай байдаг юм” гэж хэлэхэд маш дотно сайхан санагддаг. Би цаашид үсчний сургалтад хамрагдаж мэргэжилтэй болоод суллагдаж гараад өөрийн гэсэн үсчний газартай, түүнийгээ өргөжүүлээд олон салбартай болно гэж боддог”

4. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь хүмүүжигч хүүхдүүдэд хүмүүжлийн эерэг нөлөө үзүүлэх, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухаанд сургах зорилгоор Төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг. Тухайлбал “Кристина нобелийн хүүхдийн сан” төрийн бус байгууллагуудтай 20 гаруй жилийн хугацаанд хамтран сургалт, хөтөлбөр хэргжүүлсээр иржээ. Үүнд:

а. Их дээд сургууль, коллежид сургалцах тэтгэлэгт хөтөлбөр амжилттай хэрэгжүүлдэг. Тус байгууллагын дэмжлэгтэйгээр сүүлийн 2 жилийн хугацаанд 5 хүүхэд 50-100 хувийн төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр ШУТИС, МУБИС, ХААИС, УБИС, ИЗИС сургуулиудад өөрсдийн сонгосон мэргэжлээр суралцаж байна.

б. Үүнээс гадна хүүхдийн зан үйлд урлагаар дамжуулан эерэг нөлөө үзүүлэх, сэтгэл заслын эмчилгээ хийх зорилгоор “Гар зураг”-ийн дугуйлан хичээллэж 8-10 хүүхэд тогтмол хамрагддаг бөгөөд “Хөгжимийн сургалт”-ын хөтөлбөрөөр дамжуулан урлагийн боловсрол олгодог. Хүүхдүүд гитар, морин хуур хөгжмийг шимтэн суралцаж байна.

Мөн бусад төрийн бус байгууллагадтай хамтран дараах сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна. Үүнд:

- “Амин хүүхэд” төрийн бус байгууллагатай хамтран Англи хэлний сургалтыг Мягмар гараг бүр зохион байгуулж түүнд 10 хүмүүжигч тогтмол хамрагддаг

- “АМОС” төрийн бус байгууллагатай хамтран хүүүдийн зан үйлд эерэг хандлага төлөвшүүлэх “Ирээдүйн хүсэл тэмүүлэл” сэдэвт сургалтад нийт хүмүүжигч нар хамрагдаж байна.

5. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид, байгууллагын зүгээс хүмүүжигч нарын үйлдсэн гэмт хэргийн гэмт хэрэг, хувийн зан байдлын онцлогийг харгалзан “Уур бухимдалаа зохицуулах” хөтөлбөрт 18, “Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх нь” сэтгэл зүйн бүлгийн сургалтад 17 хүмүүжигчийг хамруулан долоо хоног бүрийн Лхагва, Баасан гарагуудад тогтмол хуваарийн дагуу зохион байгуулж амжилттай харагдсан хүүхдүүдэд “Батламж” олгодог. Энэ нь тэдний засрал хүмүүжил олж хугацаанаас өмнө суллагдах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэгт чухал ач холбогдолтой бөгөөд нийгмийн амьдралд эргэн орох, дахин алдаа гаргахгүй байхад тус дэм болдог.

Кейс 2. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа “Б” тус байгууллагад ирээд ерөнхий боловсролын сургуулиа төгссөн. Мөн “Нарийн боов”-ны мэргэжил эзэмшсэн. Суллагдан гараад хүмүүс миний талаар юу гэж ярих бол гэж их санаа зовдог.

6. Нийгэмд эргэн нэгтгэх, эрх чөлөөт амьдралд бэлтгэх чиглэлээр “Уур бухимдлаа зохицуулах нь”, “Харилцааны чадварт суралцах нь” болон “Асрал төв” төрийн бус байгууллагатай хамтран хүмүүжигчийн сөрөг зан байдал, харилцааны ур чадварыг сайжруулах зорилго бүхий бүлгийн сургалтыг зохион байгуулдаг.

7. Мөн суллагдах дөхсөн хүмүүжигч нарыг бичиг баримтжуулах, иргэний бүртгэлд хамруулах ажлыг орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран зохион байгуулдаг. Тухайлбал өнгөрсөн онд иргэний үнэмлэх шинээр авах 7, нөхөж авах 2 нийт 9 хүмүүжигчийн иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулжээ.

8. Хүмүүжигч нарын гэр бүлийн эерэг харилцааны хэвийн байдлыг хадгалах, гэр бүл, нийгэмтэй ойр байлгах, суллагдан гараад гэр бүлийнхээ дэмжлэгийг авч хэвийн амьдрах нөхцлийг хангах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулдаг. Тухайлбал Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т хүмүүжигчдийн гэр бүл, ойр дотны хүмүүс, хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагаас иргэд хүрэлцэн ирж оролцсон.

Өдөрлөгийн үеэр хүмүүжигчид урлагийн тоглолт үзүүлж, өөрсдийн хийсэн ноос, эсгий урлалын бүтээл, талх, нарийн боов, гар зургуудаар үзэсгэлэн гаргаж арга хэмжээнд хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчид, ар гэрийнхэндээ үзүүлсэн байна.

Кейс 3. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын ажилтан "Г" хүмүүжиж байгаа хүүхдүүдийн гэр бүлийг судлахад эцэг эхийн хараа хяналт сул, архи уудаг, ажилгүй, гэр бүл салсан, эсвэл харилцаа хандлагын хувьд доголдолтой байдаг тул эцэг эх, асран халамжлагч нарыг чадвархижуулах нь чухал.

9. Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэхэд хорих байгууллага эцэг, эх, гэр бүлийн хамтын ажиллагаа ихээхэн чухал бөгөөд тэдэнд чиглэсэн нөлөөллийн болон сургалтын ажлыг зохион байгуулах талаар сургалт хүмүүжлийн байгууллагын зүгээс ихээхэн анхааран ажилладаг.

10. Түүнчлэн хүүхэдтэй ажиллах ялангуяа гэмт хэрэг үйлдсэн, зан байдлын хувьд доголдолтой хүүхэдтэй ажиллахад сургалт хүмүүжлийн байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч бусад алба хаагчдаас хүүхэдтэй харилцах арга зүй, ур чадвар ихээхэн шаардлагатай байдаг.

Цаашид энэ чиглэлээр анхааран ажиллах, тус байгууллагад ажиллах алба хаагчдыг сонгон шалгаруулах, томилон ажиллуулахдаа анхаарах, тэднийг сургаж дадлагажуулахад анхаарах хэрэгтэй юм.

Кейс 4. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын ажилтан "Г" Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ажиллах нийт алба хаагчдыг хүүхэдтэй ажиллах арга зүйн чиглэлийн сургалтад хамруулах, тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай байдаг. Жишээ нь насанд хүрэгчдийн хаалттай хорих ангид ажиллаж байгаад шууд томилогдон ирж ажиллах тохиолдол байдаг.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь ШШГЕГ, бусад байгууллага, иргэдтэй хамтран гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийг хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, тэднийг хуулиа сахин биелүүлдэг иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, хүмүүжлийн олон талт ажлыг амжилттай хэрэгжүүлсээр ирсэн.

Гэвч өнөөдөр бидэнд анхааран авч үзэх, шийдвэрлэвэл зохих хэд хэдэн асуудал байгаа нь алба хаагчид, хүмүүжиж буй хүүхдүүдээс авсан судалгаа, тус байгууллагаас хэрэгжүүлж буй сургалт хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ зэргээс харагдаж байна. Үүнд:

Нэг. Одоогийн байгаа сургалт хүмүүжлийн байгууллага нь өмнө насанд хүрэгчдийн хорих анги байсан бөгөөд үүнээс хамааралтай хорих ангийн орчин нөхцөл хадгалагдсаар байна. Иймд тус байгууллагын орчин нөхцлийг сайжруулах, тусгайлсан дүрэм, стандартыг боловсруулж мөрдөх шаардлагатай.

Хоёр. Насанд хүрээгүй хүмүүстэй тогтмол буюу дагнан ажилладаг, насанд хүрээгүй хүнийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх асуудлыг голчлон эрхэлдэг албан хаагчид болон нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг тусгайлан бэлтгэн насанд хүрээгүй хүмүүстэй харьцах талаар мэргэшүүлэх

Гурав. Өсвөр насны хүний эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалт, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх. Гэр бүлийн харилцаа сэргээх буюу гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхэд анхаарах. Суллагдан гарсаны дараа нийгмийн ажлын үйлчилгээг тасралтгүй үр дүнтэй явуулах.